

Сурах Зорилтыг бичих заавар



Canberra Institute
of Technology

RTO Code 0101 | CRICOS No. 00001K

Та өөрийн Сурах Зорилтыг дэлгэрэнгүй бичиж бидэнд гаргаж өгнө үү.

Оюутны виз хүсч гаргасан өргөдөлтэй тань холбоотойгоор Австралийн Дотоод Хэргийн Яам танаас энэхүү баримтыг гаргаж өгнө үү хэмээн хүсч магадгүй юм.

Дотоод Хэргийн Яамны веб хуудсанд бичсэнчлэн, өргөдөл хүсэгч нь өргөдлөө зуучлагч агентлагаар дамжуулан гаргаж байгаа тохиолдолд Сурах Зорилт гэсэн нэртэй энэхүү мэдэгдлийг гаргаж өгсөн байх ёстой.

Сурах Зорилт гэсэн нэртэй таны гаргаж өгөх мэдэгдэл нь доорх мэдээллийг агуулсан байх ёстой:

Хувийн мэдээллүүд

1. Таны овог нэр болон төрсөн огноо
2. Та гэрлэсэн үү? Тийм бол:
 - Гэрлээд хэр удаан болж байгаа вэ?
 - Та нөхөр/эхнэртэйгээ хамт амьдардаг уу?
 - Та хүүхэдтэй юу?
 - Таны эхнэр/нөхөр/хүүхэд чинь тантай хамт Австралид ирэх үү?
3. Таны хамаатан садан Австралид байдаг уу? Тийм бол
 - Хаана?
 - Тэр хүвн тантай ямар хамаатай вэ?
жишээлбэл: эгч/дүү/ах/авга/ээж/аав

Энэхүү курсыг сонгосон шалтгаан:

1. CIT-ийн ямар курсэд сурахаар та өргөдөл гаргасан бэ?
2. CIT-ийн энэ курсэд сурах таны сонирхол/шалтгаан юу вэ?
3. CIT-ийн энэ чиглэлээр сурахаар та өөрийгөө хэр бэлдсэн бэ?
4. Таны ажил мэргэжил, боловсрол, ирээдүйн карьертэй таны энэ сонгосон курс хэрхэн нийцэж байгаа вэ?
5. CIT-ийн энэ курсийг сурч дуусгаад та юу хийхээр төлөвлөж байгаа вэ?
6. Таны сурч төгсөх энэ курс таны ирээдүйн амьдралд ямар хувь нэмэр оруулах вэ?
7. Та түрүүчийн сургуулиа сурч дуусгаад хамгийн багадаа 1 жил болсон бол түүнээс хойш юу хийж байгаа вэ?

Сурах Зорилтыг бичих заавар

Бие дааж хийсэн судалгаа

1. CIT-ийн энэхүү курсийн агуулга, хичээлийн тухай илүү их мэдээллийг та өөрөө яаж хэрхэн хайж олж авсан, энэ талаар өөрөө бие дааж хэрхэн судалсан талаарх баримтуудыг гаргаж өгнө үү.
2. Өөр байгаа бусад боломжуудыг хэрхэн судалсан талаар:
 - Өөрийнхөө эх орон дэх сургуулиуд
 - Канберра хотын бусад сургуулиуд
 - Австралийн бусад сургуулиуд
 - Бусад улс орны сургуулиуд

Австрали улс болон CIT сургууль таны хувьд хэрхэн хамгийн сайн сонголт болж байгаа талаар

1. Доорх дурдсан газар улс орнууд дэх сургуулиудаас та яагаад CIT-г сонгосон бэ?
 - Канберра хотын бусад сургуулиуд
 - Австралийн бусад сургуулиуд
 - Бусад улс орны сургуулиуд
 - Өөрийнхөө эх орон дэх сургуулиуд
2. Доорх дурдсан газар улс орнууд дэх сургуулиудад сурахад гарах зардал нь CIT-тэй харьцуулахад ямар байна вэ:
 - Канберра хотын бусад сургуулиуд
 - Австралийн бусад сургуулиуд
 - Бусад улс орны сургуулиуд
 - Өөрийнхөө эх орон дэх сургуулиуд
3. Австралид суралцахад гарах сургалтын төлбөр, байрны хөлс, амьжиргааны хөлс зэргээ та хэрхэн санхүүжүүлэх вэ?
4. Канберра хотод суралцах орчин нөхцөл ямар талаар та юу мэдэх вэ?